



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/195/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Ари файнэнс аудит" ХХК Захирал Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ө.ЗОЛБАЯР ТАНАА**

2025-02-25 № 10А-2025/195/НА-СТА-7413
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35 А/10/, 09 дүгээр хамтарсан тушаалын 6, 7, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалын 3.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

1. Орон тооны архив бичиг хэргийн ажилтан ажиллуулдаг атал архивын баримт материал цэгцлүүлсэн, заавар зөвлөгөө авсан гэх үндэслэлээр бусдаар гэрээгээр ажил гүйцэтгүүлэн гүнзгий сургалтын төлбөрийн буюу үйл ажиллагааны орлогоос зарцуулалт гаргаж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

432502262

2. Үйл ажиллагааны орлогыг өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслэн бодитоор төлөвлөөгүйгээс төлөвлөгөөг тасалсан.

3. Нийт 124,880.6 мянган төгрөгийн санхүүжилт бүхий Үдийн хоолны зардлын хүүхдийн ирц, материалын тооцооллыг илэрхийлсэн хоолны өдөрлөг үйлдээгүй, материалын тайланг тусгайлан гаргаагүй, хүүхдийн ирцийг бодитоор бус өдөр бүр тогтмолоор тооцож, илүү зарцуулалт гаргасан.

4. Багш, ажилтнуудын ур чадварыг журмын дагуу хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй, нэмэгдлийг сар бүр олгодоггүй.

Асуудлыг онцолсон хэсэг

БШУЯ, аймгийн Боловсролын газар, Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагаас нийт 120,160.2 мянган төгрөгийн үнэ бүхий сурах бичиг, зөөврийн компьютер, зурагт, хяналтын камер, сурагч ширээ, сандал зэрэг үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус "бараа үйлчилгээний бусад зардал" гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 8 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.8 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	259,274,370.60	439,322,348.32
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	114,563,559.96	265,481,146.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	114,563,559.96	265,481,146.98
3121	Төгрөг	114,563,559.96	265,481,146.98
31211	Төрийн сангийн харилцах	114,563,559.96	265,481,146.98
35	БАРАА МАТЕРИАЛ	144,710,810.64	173,841,201.34
351	Түүхий эд материал	131,750.00	131,750.00
35110	Тусгай зориулалттай материал	51,750.00	51,750.00
35130	Эм боох материал	80,000.00	80,000.00
354	Хангамжийн материал	144,579,060.64	173,709,451.34
35410	Бичиг хэргийн материал	792,500.00	438,900.00
35420	Аж ахуйн материал	6,753,450.00	19,685,350.00
35460	Хүнсний материал	3,988,330.00	450,000.00
35470	Бусад хангамжийн материал	133,044,780.64	153,135,201.34
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,340,537,971.06	1,393,052,146.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,340,537,971.06	1,393,052,146.94
392	Биет хөрөнгө	1,159,179,971.06	1,212,498,146.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,118,878,974.00	1,138,778,974.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-339,217,832.28	-361,287,408.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	725,761,581.28	601,069,828.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	-517,584,458.47	-339,880,827.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	189,491,571.03	189,066,669.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	-109,988,915.10	-93,294,892.64
39214	Бусад үндсэн хөрөнгө	84,414,531.48	76,296,593.48
39215	Хуримтлагдсан элэгдэл	-43,394,270.48	-43,389,717.78
39217	Ном	50,818,789.60	45,138,927.13
393	Биет бус хөрөнгө	181,358,000.00	180,554,000.00
39301	Програм хангамж	45,343,050.00	43,303,760.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-39,725,050.00	-38,489,760.00
39303	Бусад биет бус хөрөнгө	175,740,000.00	175,740,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,599,812,341.66	1,832,374,495.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,292,163.59	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,292,163.59	00.00
413	Өглөг	1,292,163.59	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	986,586.46	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	300,079.74	00.00
4136	Бусад өглөг	5,497.39	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,497.39	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,598,520,178.07	1,832,374,495.26
51	Засгийн газрын хувь оролцоо	1,598,520,178.07	1,832,374,495.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,128,928,525.00	1,128,928,525.00
51101	Өмч: - төрийн	1,128,928,525.00	1,128,928,525.00
512	Хуримтлагдсан үр дүн	-645,135,538.36	-411,281,221.17

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	-645,135,538.36	-643,950,951.90
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	232,669,730.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,114,727,191.43	1,114,727,191.43
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,599,812,341.66	1,832,374,495.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,420,656,683.31	3,043,915,455.06
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	128,466,365.64	218,753,508.10
120	Нийтлэг татварын бус орлого	128,466,365.64	218,753,508.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,083,138.00	75,245,710.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,730,248.00	22,626,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,352,890.00	52,619,210.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	48,025,061.00	120,160,276.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	15,358,166.64	23,347,521.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,292,190,317.67	2,825,161,946.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,141,522,100.00	2,646,362,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,141,522,100.00	2,646,362,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,668,217.67	178,799,046.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,668,217.67	178,799,046.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,540,347,216.41	2,792,663,463.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,540,347,216.41	2,792,663,463.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,408,363,523.91	2,655,197,644.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,598,223,906.80	1,938,719,519.46
210101	Үндсэн цалин	1,598,223,906.80	1,938,719,519.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,524,241.07	238,707,502.38
210201	Тэтгэврийн даатгал	132,138,247.68	165,445,217.02
210202	Тэтгэмжийн даатгал	15,527,086.49	19,548,317.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,408,268.55	9,603,408.20
210204	Ажилгүйдлийн даатгал	2,924,190.88	8,843,020.70
210205	Эрүүл мэндийн даатгал	29,526,447.47	35,267,539.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,093,217.67	153,799,046.96
210301	Гэрэл, цахилгаан	16,588,256.67	17,052,156.96
210302	Түлш, халаалт	101,290,197.00	110,320,836.00
210303	Цэвэр, бохир ус	18,214,764.00	26,426,054.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.0	1,036,637.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.0	00.00
210408	Бараа материал акталсны зардал	0.0	1,036,637.00
2105	Нормативт зардал	38,124,307.16	11,087,557.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		00.00
210502	Хоол, хүнс	38,124,307.16	11,087,557.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	8,900,000.00
210604	Урсгал засвар	0.0	8,900,000.00

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	0.0	00.00
210702	Дотоод албан томилолт		00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,651,608.19	47,069,139.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,300,000.00	8,179,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,351,608.19	38,889,639.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	424,746,243.02	255,878,241.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,440,740.00	110,215,781.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,904,810.00	24,105,620.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	336,400,693.02	121,556,840.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,983,692.50	137,465,819.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,983,692.50	137,465,819.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,914,492.50	124,430,719.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,069,200.00	13,035,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-119,690,533.10	251,251,991.20
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	18,582,260.47
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	18,582,260.47
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	00.00	-18,582,260.47
5	НИЙТ ҮР ДҮН	-119,690,533.10	232,669,730.73

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,357,273,455.67	2,900,407,656.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,083,138.00	75,245,710.00
120	Нийтлэг татварын бус орлого	65,083,138.00	75,245,710.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,083,138.00	75,245,710.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,730,248.00	22,626,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,352,890.00	52,619,210.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,292,190,317.67	2,825,161,946.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,141,522,100.00	2,646,362,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,141,522,100.00	2,646,362,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	150,668,217.67	178,799,046.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	150,668,217.67	178,799,046.96
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,206,654,512.55	2,676,997,069.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,206,654,512.55	2,676,997,069.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,070,682,484.89	2,539,081,399.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,598,508,240.96	1,938,719,519.46
210101	Үндсэн цалин	967,518,739.22	1,240,420,765.13
210102	Нэмэгдэл	571,029,189.20	616,305,183.89
210104	Урамшуулал	59,960,312.54	81,993,570.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,524,241.07	238,514,999.77
210201	Тэтгэврийн даатгал	132,138,247.68	165,223,913.81
210202	Тэтгэмжийн даатгал	15,527,086.49	19,554,917.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,408,268.55	9,698,258.68
210204	Ажилгүйдлийн даатгал	2,924,190.88	8,757,170.82

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	29,526,447.47	35,280,739.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	136,093,217.67	153,799,046.96
210301	Гэрэл, цахилгаан	16,588,256.67	17,052,156.96
210302	Түлш, халаалт	101,290,197.00	110,320,836.00
210303	Цэвэр, бохир ус	18,214,764.00	26,426,054.00
2105	Нормативт зардал	8,364,797.00	11,087,494.50
210502	Хоол, хүнс	8,364,797.00	11,087,494.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,575,000.00	8,900,000.00
210604	Урсгал засвар	14,575,000.00	8,900,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,778,478.19	47,069,139.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,101,000.00	8,179,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,677,478.19	38,889,639.51
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,838,510.00	140,991,199.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,993,170.00	116,837,539.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,845,340.00	24,153,660.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	135,972,027.66	137,915,670.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,972,027.66	137,915,670.74
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	118,902,827.66	124,880,570.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,069,200.00	13,035,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	150,618,943.12	223,410,587.02
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	59,003,000.00	72,493,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,003,000.00	72,493,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,003,000.00	72,493,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,003,000.00	72,493,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-59,003,000.00	-72,493,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	91,615,943.12	150,917,587.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	22,947,616.84	114,563,559.96
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	114,563,559.96	265,481,146.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2023 оны 1-р сарын 1-	1,128,928,525.00	1,114,727,191.43	-645,135,538.36	1,598,520,17.07
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,184,586.46	1,184,586.46
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,128,928,525.00	1,114,727,191.43	-643,950,951.90	1,599,704,764.53
9	Тайлант үеийн үр дүн	0	0	232,669,730.73	232,669,730.73
10	2024 оны 12-р сарын 31	1,128,928,525.00	1,114,727,191.43	-411,281,221.17	1,832,374,495.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,026,322,300.00	2,749,490,069.94	276,832,230.06	90.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,026,322,300.00	2,749,490,069.94	276,832,230.06	90.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,847,522,300.00	2,611,574,399.20	235,947,900.80	91.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,136,075,800.00	1,938,719,519.46	197,356,280.54	90.8
210101	Үндсэн цалин	1,417,964,000.00	1,240,420,765.13	177,543,234.87	87.5
210102	Нэмэгдэл	663,776,100.00	616,305,183.89	47,470,916.11	92.8
210104	Урамшуулал	54,335,700.00	81,993,570.44	-27,657,870.44	150.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	267,009,500.00	238,514,999.77	28,494,500.23	89.3
210201	Тэтгэврийн даатгал	181,566,400.00	165,223,913.81	16,342,486.19	91.0
210202	Тэтгэмжийн даатгал	21,360,800.00	19,554,917.21	1,805,882.79	91.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,680,400.00	9,698,258.68	982,141.32	90.8
210204	Ажилгүйдлийн даатгал	10,680,400.00	8,757,170.82	1,923,229.18	82.0
210205	Эрүүл мэндийн даатгал	42,721,500.00	35,280,739.25	7,440,760.75	82.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,800,000.00	153,799,046.96	953.04	100.0
210301	Гэрэл цахилгаан	18,100,000.00	17,052,156.96	1,047,843.04	94.2
210302	Түлш халаалт	118,000,000.00	110,320,836.00	7,679,164.00	93.5
210303	Цэвэр бохир ус	17,700,000.00	26,426,054.00	-8,726,054.00	149.3
2105	Нормативт зардал	11,087,500.00	11,087,494.50	5.50	100.0
210502	Хоол, хүнс	11,087,500.00	11,087,494.50	5.50	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	25,000,000.00	25,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,207,600.00	47,069,139.51	22,138,460.49	68.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,801,900.00	8,179,500.00	622,400.00	92.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,405,700.00	38,889,639.51	21,516,060.49	64.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,226,200.00	197,384,199.00	28,842,001.00	87.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	202,071,300.00	173,230,539.00	28,840,761.00	85.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,154,900.00	24,153,660.00	1,240.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,915,700.00	137,915,670.74	29.26	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	137,915,700.00	137,915,670.74	29.26	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	124,880,600.00	124,880,570.74	29.26	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,035,100.00	13,035,100.00	-	100.0

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,026,322,300.00	2,900,407,656.96	125,914,643.04	95.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,646,362,900.00	2,646,362,900.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,646,362,900.00	2,646,362,900.00	0.00	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	178,800,000.00	178,799,046.96	953.04	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	178,800,000.00	178,799,046.96	953.04	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	201,159,400.00	75,245,710.00	125,913,690.00	37.4
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	26,010,500.00	22,626,500.00	3,384,000.00	87.0
гүнз1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,289,200.00	52,619,210.00	9,669,990.00	84.5
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	112,859,700.00		112,859,700.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		114,563,559.96		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		265,481,146.98		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82	75	7	91.5
620001	Удирдах ажилтан	4	3	1	75.0
620002	Гүйцэтгэх ажилтан	61	55	6	90.2
620003	Үйлчлэх ажилтан	17	15	2	88.2
620004	Гэрээт ажилтан		2	2	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь “Хамтаараа хөгжсөн, зөв дадал хэвшилтэй хүүхэд болгон төлөвшүүлэх” зорилгыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлон ажилласан байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурч, хөгжих хүнлэг энэрэнгүй, амар тайван орчин бүрдүүлж, ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэн, эерэг хандлага, соёлыг төлөвшүүлэх.
- Ээлжит хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулж, сурагчдын өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлж, шинжлэх ухаанч хандлагыг төлөвшүүлэх.
- Цахим системд суурилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж, сурагчдыг чадваржуулах.
- Сурагчдын авьяас чадварыг нээн хөгжүүлэх дугуйлан секцийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн оролцоо, хамгааллыг хангах.
- Багшийн хөгжил, манлайлал, цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах.
- Эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, эрхийн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 06 дугаар сарын 05-нд,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 12, 06 дугаар сарын 05-нд,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 01 дүгээр сарын 17, 12 дугаар сарын 12-нд,
- Төрийн албаны тухай хуульд 2024 оны 05 дугаар сарын 16, 06 дугаар сарын 05-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БЕГ-ын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 232,562.15 мянган төгрөгөөр буюу 14.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
31	Мөнгөн хөрөнгө	114,563.56	265,481.15	150,917.59
35	Бараа материал	144,710.81	173,841.20	29,130.39
39	Үндсэн хөрөнгө	1,340,537.97	1,393,052.15	52,514.18
3	Нийт хөрөнгийн дүн	1,599,812.34	1,832,374.50	232,562.15
4	Нийт өр төлбөр	1,292.16	00.00	(1,292.16)
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,598,520.18	1,832,374.50	233,854.32
51	Засгийн газрын хувь оролцоо	1,598,520.18	1,832,374.50	233,854.32
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,599,812.34	1,832,374.50	232,562.15

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 265,481.15 мянган төгрөг байгаа нь төсвийн хэмнэлттэй холбоотой,
- Бараа материал дансны үлдэгдэл 173,841.20 мянган төгрөг болж 29,130.3 мянган төгрөгөөр өссөн нь, аймгийн БШУГ, БЕГ, Хос анар ХХК-аас нийт 23,347.5 мянган төгрөгийн сурах бичиг, газрын зураг зэрэг сургалтын хэрэгслийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 242,670.3 мянган төгрөгийн бараа материал бэлтгэснээр өссөн болон 235,850.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,393,052.15 мянган төгрөг болж 52,514.18 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 72,493.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, программ хангамжийг худалдан авч, БШУЯ, аймгийн Боловсролын газар, БЕГ-аас 120,160.2 мянган төгрөгийн үнэ бүхий компьютер, техник хэрэгсэл, тавилга эд хогшлыг үнэ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
 төлбөргүйгээр хүлээн авч, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 90 дугаар тогтоолыг үндэслэн 313,707.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хассан ба 121,556.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,085,241.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналыг 130,041.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 2,215,282.3 мянган төгрөгөөр баталсан ба тайлант онд төсөвт 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 2,646,362.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 178,800.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 26,010.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 62,289.2 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 112,843.4 мянган төгрөг зэрэг нийт 3,026,306.0 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу улсын төсвөөс 2,646,362.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 178,799.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 22,626.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 52,619.2 мянган төгрөг зэрэг нийт 2,900,407.6 мянган төгрөг төвлөрүүлж, 2,749,490.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,749,490.0 мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь сургалт семинарын зардлыг 1,916.6 мянган төгрөгөөр, эрүүл мэндийг дэмжих зардлыг 2,001.2 мянган төгрөг, зөв монгол хүүхэд хөтөлбөрийн зардлыг 718.5 мянган төгрөг, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 90,060.4 мянган төгрөг, үдийн цай хөтөлбөрийн зардлыг 17,010.3 мянган төгрөгөөр, гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын зардлыг 2,965.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80226-байр ашиглалтын үйлчилгээ	6,032.6	6,032.6	0.0	100.0
2	80233- Хүүхэд хамгаалал	6,269.8	6,269.5	0.3	100.0
3	80312-сургалт семинар	6,053.4	5,920.0	133.4	97.8
4	81605 - Эрүүл мэндийг дэмжих	6,619.1	6,618.0	1.1	99.98
5	81801-үдийн цай	124,880.6	124,880.6	0.0	100.0
6	81816 - Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	55,101.6	55,093.0	8.6	99.98

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

7	81823 - Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	20,049.9	9,709.7	10,340.2	48.43
8	81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2,441,700.1	2,199,332.2	242,367.9	90.07
9	81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагаа	78,375.5	76,826.7	1,548.8	98.02
10	81844-гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	69,941.4	63,956.9	5,984.5	91.44
11	81848-сурах бичгийн түрээс	8,801.9	8,179.5	622.4	92.93
12	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	13,606.4	7,782.4	5,824.0	57.2
13	83603-дээд шатны төсвөөс хуваарилсан	10,090.0	90.0	10,000.0	0.89
Дүн		2,847,522.3	2,570,691.0	276,831.2	90.3
14	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	178,800.0	178,799.0	1.0	99.9
Нийт дүн		3,026,322.3	2,749,490.0	276,832.2	90.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад оролцогч ирээгүй тул Сэлэнгэ хатан ерөө ХХК, Алтан есүй ХХК, Алтан тариа ХХК, Номун сэлэнгэ ХХК, Цахим ертөнц ХХК, иргэн Л.Өлзийсайхан, Д.Баатар нартай шууд гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари файнэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари файнэнс аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,540,347.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 38,105.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 28 төрлийн 167 мэдээллийг байршуулсан боловч цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хавсралт файлууд /шийдвэрийн хуулбар/-ыг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байх зөвлөмж өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн өр төлбөр үүсгэхгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан бол шилэн дансны цахим хуудаст мэдээллийн хавсралт файлыг байршуулаагүй зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1		100
Зөвлөмж	1	1,292.2			
Нийт дүн	2	1,292.2	1		100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 13,650.8 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа

- Төрийн сангийн харилцах дансны үлдэгдлийг 13,650.8 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн.

Аудитаар нийт **20,142.5** мянган төгрөгийн зөрчил илэрч, 4 албан шаардлага, 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Орон тооны архив, бичиг хэргийн ажилтан ажиллуулдаг атал архивын баримт материал цэгцлүүлсэн, заавар зөвлөгөө авсан гэх үндэслэлээр аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн ажилтан М.Агиймаатай гэрээ байгуулж, гүнзгий сургалтын төлбөрийн буюу үйл ажиллагааны орлогоос 3,100.0 мянган төгрөг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Цайны газрын туслах үйл ажиллагааны орлогыг өмнөх онуудын гүйцэтгэл /2022 онд 35,240.5 мянган төгрөг, 2023 онд 34,352.9 мянган төгрөг төвлөрүүлсэн/-д үндэслэлгүйгээр хэт өндрөөр буюу 62,289.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 52,619.2 мянган төгрөг төвлөрүүлэн төлөвлөгөөг 9,670.0 мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар **төлөвлөж, зарцуулах**”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого ... -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон.. үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан... жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг өмнөх онуудын гүйцэтгэл, тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3. Нийт төсвийн 4.5 хувийг эзэлж буй 124,880.6 мянган төгрөгийн санхүүжилт бүхий Үдийн хоолны анхан шатны баримтын бүрдүүлэлт, тооцоолол, гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- Хүүхдийн ирц, орц, норм, материалын зарцуулалтыг тооцсон хоолны өдөрлөг, хүнсний материалын орлого зарлагыг тооцсон материалын тайланг тусгайлан гаргаагүй зэргээр анхан шатны баримтын бүрдлийг хангалгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн нь хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна.
- Хүүхдийн ирцийг өдөр бүр бодитоор бус тогтмол тоогоор тооцож, хүнсний материалыг зарцуулсан байна. Тухайлбал, аудитын явцад тайлант оны 9,10,11 дүгээр саруудын үдийн хоолны ирцийг жижүүр багшийн бүртгэсэн ирцтэй тулган баталгаажуулж, түүвэрлэж үзэхэд 9 дүгээр сард 327 хүүхэд буюу 490.5 мянган төгрөг, 10 дугаар сард 346 хүүхэд буюу 519.0 мянган төгрөг, 11 дүгээр сард 309 хүүхэд буюу 463.0 мянган төгрөг, нийт 982 хүүхэд буюу 1,472. 5 мянган төгрөгийн илүү зардал гаргасан байна. / 9 дүгээр сард 5 өдөр 500 хүүхдээр, 16 өдөр тус бүр 495 хүүхдээр, 10 сарын бүх өдөр 495 хүүхдээр, 11 сарын бүх өдөр 490 хүүхдээр тус тус тооцсон/

Шийдвэрлэсэн нь: Үдийн хоол, дотуур байрны хүүхдийн ирцийг бодитоор тооцон хүнсний материалыг зарцуулах, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

4.Багш нарын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнэдэггүй, нэмэгдлийг сар бүр олгодоггүй буюу зөвхөн тухайн үеийн гаргасан амжилтыг үнэлж, дүгнэн нэмэгдэл олгож байна. Тухайлбал захирлын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/08 дугаар тушаалаар 11 багшийг тус бүр 10-30 хувиар тооцож, 2,746.0 мянган төгрөг, 4 сарын 22-ны өдрийн Б/14 дүгээр тушаалаар 15 хүнийг 10-30 хувиар тооцож, 3,155.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон бол жижүүр, үйлчлэгч зэрэг үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг үнэлээгүй, ур чадварын нэмэгдэл огт олгоогүй байна.

Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, 09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь : Ур чадварын нэмэгдлийг журмын дагуу хагас жил тутам шалгуур үзүүлэлтүүдийн дагуу дүгнэж, батлагдсан төсөвт багтаан нэмэгдлийг сар бүр олгож байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал:

1.1. **Илрүүлэлт:** Сургуулийн эмчийн эмийн хөдөлгөөний тайланг гаргуулдаггүй, жилийн эцэст эмийн тооллогыг хийгээгүй, тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2: "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1: "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг хуульд заасан хугацаанд гүйцэтгэж, үлдэгдлийг баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Харилцах дансны үлдэгдлийг зөрүүтэй илэрхийлсэн	1	13,650.0			1	13,650.0	1	13,650.0				
Дүн	1	13,650.0			1	13,650.0	1	13,650.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Төлбөрийн акт	Албан шаардлага	Үүнээс		
				Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2024 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан	1	3,100.0			1	3,100.0						
Үйл ажиллагааны орлогыг үндэслэлгүй төлөвлөснөөс төлөвлөгөөг тасалсан	1	9,670.0			1	9,670.0						
Үдийн хоолны зарцуулалтын анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, тайлан тооцоо, хүүхдийн ирцэнд хяналт тавиагүйгээс илүү зарцуулсан	1	1,472.5			1	1,472.5						
Ур чадварын нэмэгдийг журмын дагуу тооцож, олгоогүй	1	5,901.0			1	5,901.0						
Эмчийн эмийн тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй	1						1					
Дүн	5	20,143.5			4	20,143.5	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах хавсралт файлууд байршуулаагүй	1							1	
Дүн	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1						1	1	



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 147/А.1850.385
00А-2025/145/НА-СТА-ТШС

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Багш, ажилтнуудын ур чадварыг хагас жил тутам холбогдох үзүүлэлтүүдээр үнэлж, дүгнээгүй, нэмэгдлийг сар бүр олголгүйгээр тус бүр 10-30 хувиар тооцож, 02 дугаар сард 11 багшид 2,746.0 мянган төгрөг, 04 дүгээр сард 15 багшид 3,155.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь БШУС, ХНХС, Сангийн сайдын 2021 оны А/35, А/10/, 09 дүгээр хамтарсан тушаалаар баталсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 6-д “Багш, ажилтны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдлийг сар бүр олгоно”, 7-д “Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60.0 болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгдэл олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11: “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Багш, ажилтнуудын ур чадварыг журмын дагуу үнэлж, дүгнээгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн захирал Ө.Золбаяр, нягтлан бодогч Б.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504441

1944

13520444



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 157 / А1250385

Сүхбаатар

107А-2025/195/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Үдийн хоолны хүүхдийн ирц, орц, норм, материалын зарцуулалтыг тооцсон хоолны өдөрлөг, хүнсний материалын тайланг тусгайлан гаргаагүй зэргээр анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ажил гүйлгээг гүйцэтгэсэн, хүүхдийн ирцийг бодитоор бус өдөр бүр тогтмол тоогоор тооцож, 1,472.5 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: " 4.2.1.1. нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Үдийн хоолны хүүхдийн ирцийг бодитоор тооцоогүй, хоолны өдөрлөг, материалын тайлан гаргаагүй зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн захирал Ө.Золбаяр, нягтлан бодогч Б.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504452



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар

137/АИЗД385

Сүхбаатар

100-2025/195/11А-СТА-7113

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Орон тооны архив, бичиг хэргийн ажилтан ажиллуулдаг атал архивын баримт материал цэгцлүүлсэн, заавар зөвлөгөө авсан гэх үндэслэлээр аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн ажилтан М.Агиймаатай гэрээ байгуулж, гүнзгий сургалтын төлбөрийн буюу үйл ажиллагааны орлогоос 3,100.0 мянган төгрөг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.Үүнд: ” 4.2.1.6. “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн захирал Ө.Золбаяр, нягтлан бодогч Б.Сарантуяа нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА

432504469



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 158/А/25-0385

Сүхбаатар

00А-2025/195/НА-ОТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар үйл ажиллагааны орлогыг тооцоо судалгаагүйгээр хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалан төлөвлөгөөг 9,670.0 мянган төгрөгөөр тасалсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2022 оны А/282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь “Энэ журмын 3.1.1-т заасан орлого ... -ын сүүлийн 3 жилийн гүйцэтгэл болон.. үйл ажиллагаанд хамаарч үргэлжлэх байдлыг тус тус харгалзан... жилийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд: ” 4.2.1.11 дэх “Хууль тогтоомж, ... зөрчсөн ...” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөөгүй зөрчлийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн захирал Ө.Золбаяр, нягтлан бодогч Б.Сарантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

Д.АРИУНАА



432504472